



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгийсумын ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **БӨА-2025/163/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2025 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын,

дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: aigul@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн захирал: М.Нурболат

Утас: 70007275 Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 10 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ К.ЕРКЕГҮЛ ТАНАА**

2025.02.24 № 155
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Өлгий сумын ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өлгий сумын ерөнхий боловсролын 10 дугаар сургууль нь 2024 онд 1,546.3 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,288.1 сая төгрөг зарцуулж, 83.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Өлгий сумын ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилго, 8 орилтын хүрээнд нийт 75 арга хэмжээ 95.5 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	163,267,102.73	281,709,619.75
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	135,522,643.13	259,207,550.15
3121	Төгрөг	135,522,643.13	259,207,550.15
31211	Төрийн сангийн харилцах	135,522,643.13	259,207,550.15
33	АВЛАГА	10,700,000.00	3,500,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	10,700,000.00	3,500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	17,044,459.60	19,002,069.60
354	Хангамжийн материал	17,044,459.60	19,002,069.60
35420	Аж ахуйн материал	-	550,000.00
35460	Хүнсний материал	940,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	16,104,459.60	18,452,069.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,395,141,616.35	3,400,456,110.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,395,141,616.35	3,400,456,110.00
392	Биет хөрөнгө	3,369,396,564.81	3,377,120,331.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,495,048,697.00	3,495,048,697.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(268,925,312.16)	(356,144,332.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	87,401,132.80	171,085,501.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,984,872.59)	(40,287,715.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,903,736.00	103,952,136.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,366,206.76)	(32,509,298.80)
39217	Ном	29,319,390.52	35,975,343.52
393	Биет бус хөрөнгө	25,745,051.54	23,335,778.78
39301	Програм хангамж	10,097,739.00	10,097,739.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,808,687.46)	(7,217,960.22)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,456,000.00	20,456,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,558,408,719.08	3,682,165,729.75
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	9,139,862.43
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	9,139,862.43
413	Өглөг	-	9,139,862.43
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	640,510.00
4136	Бусад өглөг	-	8,499,352.43
41361	Байгууллагад төлөх өглөг	-	8,499,352.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,558,408,719.08	3,673,025,867.32
51	Засгийн газрын хувь оролцоо	3,558,408,719.08	3,673,025,867.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,456,000.00	20,456,000.00
51101	Өмч:- төрийн	20,456,000.00	20,456,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,537,952,719.08	3,652,569,867.32
51210	Өмнөх үеийн үр дүн	3,537,952,719.08	3,537,952,719.08
51220	Тайлант үеийн үр дүн	-	114,617,148.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,558,408,719.08	3,682,165,729.75

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,100,404,917.32	1,503,444,820.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	92,637,320.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	92,637,320.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	7,912,277.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,686,667.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	12,802,917.32	84,725,043.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	225,610.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,087,602,000.00	1,410,807,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,027,520,700.00	1,339,927,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,027,520,700.00	1,339,927,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,081,300.00	70,880,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,081,300.00	70,880,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,111,491,267.11	1,388,827,671.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,111,491,267.11	1,388,827,671.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,015,019,167.11	1,257,812,544.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	726,915,658.87	902,157,049.00
210101	Үндсэн цалин	494,241,464.80	617,445,138.00
210102	Нэмэгдэл	176,631,499.46	252,965,715.00
210104	Урамшуулал	56,042,694.61	31,746,196.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,251,600.00	114,571,423.00
210201	Тэтгэврийн даатгал	60,691,500.00	89,740,323.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,140,400.00	6,207,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,712,000.00	3,103,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,427,700.00	3,103,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,280,000.00	12,415,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,036,300.00	81,748,352.43
210301	Гэрэл, цахилгаан	16,636,300.00	22,499,352.43
210302	Түлш, халаалт	32,100,000.00	31,249,000.00
210303	Цэвэр, бохир ус	8,300,000.00	28,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,300,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,147,800.00	10,320,731.98
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,997,800.00	10,320,731.98
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	150,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,667,808.24	147,714,988.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,874,301.00	18,328,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,099,400.00	11,311,810.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	112,694,107.24	118,074,228.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,472,100.00	131,015,127.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,427,100.00	127,060,460.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	95,427,100.00	120,389,950.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,670,510.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,045,000.00	3,954,667.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,045,000.00	3,954,667.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(11,086,349.79)	114,617,148.24
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(11,086,349.79)	114,617,148.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,087,602,000.00	1,418,494,167.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	7,686,667.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	7,686,667.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	7,686,667.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,686,667.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,087,602,000.00	1,410,807,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,027,520,700.00	1,339,927,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,027,520,700.00	1,339,927,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,081,300.00	70,880,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,081,300.00	70,880,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	999,125,142.87	1,256,145,580.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	999,125,142.87	1,256,145,580.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	901,713,042.87	1,126,073,963.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	725,913,742.87	931,931,172.00
210101	Үндсэн цалин	493,239,548.80	647,219,261.00
210102	Нэмэгдэл	176,631,499.46	252,965,715.00
210104	Урамшуулал	56,042,694.61	31,746,196.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,251,600.00	77,597,300.00
210201	Тэтгэврийн даатгал	60,691,500.00	52,766,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,140,400.00	6,207,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,712,000.00	3,103,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,427,700.00	3,103,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,280,000.00	12,415,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,036,300.00	72,612,000.00
210301	Гэрэл, цахилгаан	16,636,300.00	14,000,000.00
210302	Түлш, халаалт	32,100,000.00	30,612,000.00
210303	Цэвэр, бохир ус	8,300,000.00	28,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,537,800.00	10,590,731.98
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,537,800.00	10,590,731.98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,973,600.00	31,342,760.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,832,700.00	19,610,760.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,140,900.00	11,732,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,412,100.00	130,071,617.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,367,100.00	126,116,950.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	96,367,100.00	120,086,950.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,030,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,045,000.00	3,954,667.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,045,000.00	3,954,667.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	88,476,857.13	162,348,586.02
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33,968,700.00	38,663,679.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,968,700.00	38,663,679.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,968,700.00	38,663,679.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,968,700.00	38,663,679.00

Өлгий сумын ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(33,968,700.00)	(38,663,679.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	54,508,157.13	123,684,907.02
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	81,014,486.00	135,522,643.13
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	135,522,643.13	259,207,550.15

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн / төгрөгөөр /
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,456,000.00	3,549,039,068.87	3,569,495,068.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,456,000.00	3,549,039,068.87	3,569,495,068.87
Тайлант үеийн үр дүн	-	(11,086,349.79)	(11,086,349.79)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,456,000.00	3,537,952,719.08	3,558,408,719.08
2024 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	20,456,000.00	3,537,952,719.08	3,558,408,719.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,456,000.00	3,537,952,719.08	3,558,408,719.08
Тайлант үеийн үр дүн	-	114,617,148.24	114,617,148.24
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,456,000.00	3,652,569,867.32	3,673,025,867.32

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь /Төгрөгөөр/
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,546,313,900.00	1,288,107,592.98	258,206,307.02	83.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,546,313,900.00	1,288,107,592.98	258,206,307.02	83.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,410,724,600.00	1,161,990,642.98	248,733,957.02	82.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,093,331,000.00	932,531,172.00	160,799,828.00	85.3
210101	Үндсэн цалин	751,723,300.00	647,819,261.00	103,904,039.00	86.2
210102	Нэмэгдэл	318,310,600.00	252,965,715.00	65,344,885.00	79.5
210104	Урамшуулал	23,297,100.00	31,746,196.00	(8,449,096.00)	136.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,666,300.00	77,597,300.00	59,069,000.00	56.8
210201	Тэтгэврийн даатгал	92,933,100.00	52,766,200.00	40,166,900.00	56.8
210202	Тэтгэмжийн даатгал	10,933,300.00	6,207,900.00	4,725,400.00	56.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,466,600.00	3,103,800.00	2,362,800.00	56.8
210204	Ажилгүйдлийн даатгал	5,466,600.00	3,103,800.00	2,362,800.00	56.8
210205	Эрүүл мэндийн даатгал	21,866,700.00	12,415,600.00	9,451,100.00	56.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,880,000.00	68,880,000.00	-	100.0

Өлгий сумын ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	14,000,000.00	14,000,000.00	-	100.0
210302	Түлш, халаалт	26,880,000.00	26,880,000.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	28,000,000.00	28,000,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,305,000.00	21,659,330.98	9,645,669.02	69.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,305,000.00	21,659,330.98	9,645,669.02	69.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,542,300.00	59,322,840.00	19,219,460.00	75.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,717,500.00	47,590,840.00	19,126,660.00	71.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,824,800.00	11,732,000.00	92,800.00	99.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,589,300.00	126,116,950.00	9,472,350.00	93.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,589,300.00	126,116,950.00	9,472,350.00	93.01
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	129,184,200.00	120,086,950.00	9,097,250.00	92.96
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,405,100.00	6,030,000.00	375,100.00	94.14
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,546,313,900.00	1,411,792,500.00	134,521,400.00	91.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,339,927,500.00	1,339,927,500.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,339,927,500.00	1,339,927,500.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	70,880,000.00	70,880,000.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	70,880,000.00	70,880,000.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	135,506,400.00	985,000.00	134,521,400.00	0.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		985,000.00	(985,000.00)	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-	-	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	135,506,400.00	-	135,506,400.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		135,522,643.13	(135,522,643.13)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		259,207,550.15	(259,207,550.15)	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42	42	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	23	23	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	18	18	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өлгий сумын ерөнхий боловсролын 10 дугаар сургууль нь бага боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм. Эрхэм зорилго нь “Тохилог орчин чанартай сургалт явуулахад оршино.”

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд сургуулийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам” батлах тухай
- Засгийн газрын 2024 оны 104 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам” батлах тухай
- Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоол “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах” тухай
- Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баян-Өлгий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022, 2023 оны санхүүгийн баримтад шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Өлгий сумын ерөнхий боловсролын 10 дугаар сургууль нь 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 31 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 123,757.1 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	135,522.6	259,207.6	123,685.0
Авлага	10,700.0	3,500.0	(7,200.0)
Бараа материал	17,044.5	19,002.1	1,957.6
Үндсэн хөрөнгө	3,395,141.6	3,400,456.1	5,314.5
Нийт хөрөнгө	3,558,408.7	3,682,165.8	123,757.1
Өр төлбөр	-	9,139.9	9,139.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,558,408.7	3,673,025.9	114,617.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,558,408.7	3,682,165.8	123,757.1

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 123,685.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд улсын төсвөөс 1,339,927.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 70,880.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 4,717.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого бүрдүүлж, 1,291,839.6 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 3,500.0 мянган төгрөг болж 7,200.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд авлага баарагдуулсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 19,002.1 мянган төгрөг болж 1,957.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 225.6 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, урсгал санхүүжилтээс 179,369.4 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 177,637.4 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,400,456.1 мянган төгрөг болж, 5,314.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 38,663.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 84,725.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, 118,074.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 9,139.9 мянган төгрөгөөр өссөн нь цахилгаан ашигласны төлбөр 8,499.4 мянган төгрөг, татварын өглөг 640.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 114,617.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлан оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,081,924.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 70,880.0 мянга, нийт зарлагыг

1,152,804.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийг анх цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 802,066.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 100,258.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 21,678.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 45,328.4 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 112,592.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 68,880.0 мянган төгрөг, эд,хогшил урсгал засварын зардал 2,000.0 мянган төгрөгөөр нийт 1,152,804.7 мянган төгрөгөөр баталсан. Энэ нь төсвийг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Тодотголоор 393,509.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт төсвийг 1,546,313.9 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 291,264.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 36,408.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 9,626.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 33,213.9 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 22,996.6 мянган төгрөгөөр тус тус нэмж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,339,927.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 70,880.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 135,207.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжихээр төсөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын 1,339,927.5 төсвөөс мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 70,800.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 985.0 мянган төгрөгийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд оны эхний үлдэгдлээс 135,522.6 мянган төгрөг, тайлант хугацааны санхүүжилтээс 1,152,584.9 мянган төгрөг, нийт 1,288,107.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Нийт төсвийн гүйцэтгэл 1,288,107.6 мянган төгрөг буюу 83.3 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг 225,301.8 мянган төгрөг, сургуулийн үдийн цайны хөтөлбөрийн төсвийг 9,097.2 мянган төгрөг, эрүүл мэндийг дэмжих төсвийг 3,262.6 мянган төгрөг, Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх төсвийг 5,725.5 мянган төгрөг, боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх төсвийг 8,868.6 мянган төгрөгөөр хэмнэсэн буюу тодруулбал, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 160,799.8 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 59,069.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 19,219.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 9,645.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71802 – ерөнхий боловсрол	1,546,313.90	1,288,107.60	258,206.3	83.5
1.1	80111 - төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	70,880.0	70,880.0	-	100.0
1.2	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,168.4	3,168.4	-	100.0
1.3	80233 - хүүхэд хамгаалал	3,196.6	-	3,196.6	-
1.4	80312- Сургалт семинар	3,280.5	910.0	2,370.5	27.7
1.5	81605 - эрүүл мэндийг дэмжих	5,362.6	2,100.0	3,262.6	39.2
1.6	81801 – үдийн цай хөтөлбөр	129,184.2	120,087.0	9,097.2	93.0
1.7	81816 - зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	22,528.0	22,520.1	7.9	100.0
1.8	81823 - боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	8,868.6	-	8,868.6	-

1.9	81834 - боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,257,252.8	1,031,951.0	225,301.8	82.1
1.10	81835 - сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	34,562.2	34,186.7	375.5	98.9
1.11	81875- Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	8,030.0	2,304.5	5,725.5	28.7

Хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 83.5 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Цэнгэл сумын нь Ахмадын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан ажиллуулах журам”-ыг хэрэгжүүлээгүй буюу ахмадын сан байгуулж ажиллаагүй байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж ажиллаагүй байна. Бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 47.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулан авч хянаж үзэхэд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дугаар хамтарсан тушаалаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг нормативыг баримтлан ажилласан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

2024 оны төсвийн жилд худалдан авалтын төлөвлөгөө гараагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд хүнсний материал 119,449.9 мянган төгрөгөөр, хангамжийн материал 2,122.0 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 15,844.5 мянган төгрөгөөр, түлш шатах тослох материал 31,249.0 мянган төгрөгөөр, бичиг хэргийн материал 10,704.0 мянган төгрөгөөр тус тус худалдаж авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотойгоор цалингийн нэмэгдэл урамшуулал, үндсэн хөрөнгийн бүртгэл болон баримт баталгаажуулалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Лайт энд Дилайт Аудит” ХХК-ийн аудитор Л.Мөнхцэцэг гүйцэтгэж, аудитын менежер Ц.Төмөрсүх, компанийн захирал М.Нурболат нар анхан шатны чанарын хяналтыг, Баян-

Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,100,404.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 16,672.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 31 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 14 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш нийт 77 удаагийн 1,437,901.6 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ мэдээлэхээс 22 удаагийн 181,095.9 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон, 55 удаагийн 1,256,805.7 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй орлого, зарлагын гүйлгээг нөхөж байршуулах, мэдээллийг хугацаанд нь байршуулах.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,318,1 мянган төгрөгийн зөрчилд 1 акт, 171,235.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн нь 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3,318.1	1	3,318.1	100.0
Зөвлөмж	3	171,235.4	3	171,235.4	100.0
Нийт дүн	4	174,753.5	4	174,753.5	100.0

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн.

Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 36,974.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав. Залруулсан алдаа:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшилын зардал, ажил олгогчоос төлөх шимтгэлийн зардлыг хооронд гүйлгэж бүртгэснийг залруулав.

Аудитаар нийт 11,216.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,732.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3,984.0 мянган төгрөгийн албан шаардлага, 3,500.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгч ажилласан.

5.2 Төлбөрийн акт

Аудитаар 3,732.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

1. Сургууль нь Юнител ХХК, Мобиком ХХК-аас түрээсийн орлогоос орон нутгийн төсвийн санхүүжилтийн дансанд нийтдээ 7,686.6 мянган төгрөгийн орлого оруулж үүнээс 3,954.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 3,732.0 мянган төгрөгийг зохих зөвшөөрөлгүйгээр түлш халаалтын зардалд зарцуулсан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2-ийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 42 дугаар зүйлийн 42.3.1-д “төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэсэн заалт, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

5.1 Албан шаардлага

Аудитаар 3,984.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөв.

1.БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 2/2772 дугаар бүхий албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар нягтлан бодогчид 2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 2,942,000 төгрөгийн балансын урамшуулал, эд хариуцагчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 1,042,000 төгрөгийн балансын урамшуулал тус тус олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн ажилчдад олгох мөнгөн урамшууллыг холбогдох хууль, журам зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт: Сургууль нь 2024.12.31-ний байдлаар 3,500.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаагаас 2,800.0 мянган төгрөг нь өмнөх оны үлдэгдэл, тайлант хугацаанд үүссэн 700.0 мянган төгрөгийн авлагыг цалингаас суутгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2.Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, авлага үүсгэсэн зөрчлийг арилгаж, авлагыг барагдуулах.

2. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт: Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨБАҮХАТ)-ийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.5 "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 45 дугаар зүйлийн 45.3. "Энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна", Засгийн газрын 2025 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2.Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Туслах үйл ажиллагааны орлоготой холбоотой асуудал

3.1.Илрүүлэлт: Үүрэн холбооны оператор компаниуд /Юнител сарын 300.0 мянган төгрөг, Мобиком сарын 350.0 мянган төгрөг/-ын антен байршуулахдаа орон нутгийн өмчийн газартай 3 талт гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна", Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмын "Хоёр. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулах 12. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журамд нийцүүлэн бичгээр байгуулна. 13. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг байгуулахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварыг үндэс болгоно. 14. Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар батлуулан Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлнэ. 15. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний хугацааг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол түрээслэж буй эд хөрөнгийн шинж байдал, зориулалт, онцлогийг харгалзан талууд харилцан тохиролцож тогтооно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

3.1.Өгсөн зөвлөмж: Үүрэн холбоотой компаниудтай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварын дагуу гэрээ байгуулж, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журмыг хэрэгжүүлэн ажиллах.

4. Бараа материалтай холбоотой асуудал

4.1.Илрүүлэлт: Тус сургуулийн халаалтын нүүрсийг "Хүлэг ирээдүй" ХХК-аар 2020 оноос гэрээгээр гүйцэтгүүлж ирсэн бөгөөд тайлант хугацаанд тус компаниас худалдаж авсан нүүрсний үнэд 30,612.0 мянган төгрөгийг шилжүүлсэн. Сонгон шалгаруулалт явуулаагүйгээс гадна худалдаж авсан нүүрсийг санхүүгийн тайланд бараа материалын дансанд бүртгэж тайлагнасан боловч нярвыг дамжуулаагүй, бараа материалын тайлан гаргуулаагүй, хөрөнгийн бүртгэл, төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион

байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, 20 дугаар зүйлийн 20.1.3 “аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

4.2.Өгсөн зөвлөмж: Худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаж, сонгон шалгаруулалт зохион байгуулж шалгарсан этгээдээс худалдан авалт хийх, хөрөнгийг эд хариуцагчаар орлогод авхуулж тайлан гаргуулж байх, хяналтыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Алдааны товч утга		Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл										Зөвлөмж					
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй				Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин хөлс болон нэмэгдэл урамшиллын зардал, ажил олгогчоос төлөх шийтгэлийн зардлыг хооронд гүйлгэж бүртгэсэн		1	36,974.1	-	-	1	36,974.1	-	-	1	36,974.1	1	36,974.1	-	-	-	-
ДҮН		1	36,974.1	-	-	1	36,974.1	-	-	1	36,974.1	1	36,974.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл										Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал		
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Сургууль нь өмнөх оны 3,500.0 мянган төгрөгийн, тайлант хугацаанд үүссэн 700.0 мянган төгрөгийн авлагыг суутгаагүй байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн байна.	1	3,500.0	-	-	-	-	-	1	3,500.0	-	-	-	-
Үүрэн холбооны оператор компаниудын антень байршуулахдаа Орон нутгийн өмчийн газартай 3 талт гэрээ байгуулаагүй байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
"Хүлэг ирээдүй" ХХК-аас худалдаж авсан нүүрсийг нярвыг дамжуулаагүй, бараа материалын тайлан гаргуулаагүй, хөрөнгийн бүртгэл, төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Нягтлан бодогч, эд хариуцагч нарт балансын урамшуулал олгосон	1	3,984.0	-	-	-	1	3,984.0	-	-	-	-	-	-
Туслах үйл ажиллагааны орлогыг зохих зөвшөөрөлгүйгээр зарцуулсан	1	3,732.0	1	3,732.0	-	-	-	-	-	-	-	-	-
ДҮН	6	11,216.0	1	3732.0	1	3,984.0	4	3,500.0	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 22 удаагийн 181095.9 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон, 55 удаагийн 1256805.7 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.	1	1,256,805.7	-	-	-	-	1	1,256,805.7
ДҮН	1	1,256,805.7	-	-	-	-	1	1,256,805.7